VCIP-VD

(“Гарааны капитал хөрөнгө оруулалтын хөтөлбөр – Гарааны өрийн санхүүжилт”)

Байршил: Бүс нутаг

Төслийн дугаар: 52407

Бизнесийн салбар: Мэдээлэл, харилцаа холбооны технологи

Мэдэгдлийн төрөл: Хаалттай

Байгаль орчны ангилал: FW

Батлагдах огноо: 2021 оны 3 дугаар сарын 10

Төлөв байдал: **Үзэл баримтлалыг хянасан**

Англи хэлээрх ТХББ-ийг нийтэд танилцуулсан: 2021 оны 2 дугаар сарын 2

Төслийн танилцуулга

ЕСБХБ хувь эзэмших зорилгоор гаднаас хөрөнгө оруулсан, өсөлтийнхөө үе шатанд байгаа гарааны технологийн компаниудад хөрөнгө оруулалт хийхийг зорьж байна. Энэ арга хэмжээг 10 сая евро хүртэлх хөрөнгө оруулалт бүхий гарааны зээлийн санхүүжилтийн хэрэгсэл (venture debt instrument) ашиглах замаар Банкны үйл ажиллагааны орнуудад хэрэгжүүлж, VCIP-VD буюу ЕСБХБ-наас хэрэгжүүлж ирсэн “Гарааны капитал хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн шинэ хэрэгсэл бөгөөд 120 сая евроны зориулалтын хөрөнгө бүхий механизм болох “Гарааны капитал хөрөнгө оруулалтын хөтөлбөр – Гарааны өрийн санхүүжилт”-ээр дэмжиж ажиллах юм. Бизнесийн шилдэг загвар нэвтрүүлсэн, орлого нь байнга нэмэгдэж байгаа, инновацийг дэмжигч, өндөр өсөлттэй жижиг болон дунд хэмжээний аж ахуйн нэгжүүдэд тус хөрөнгө оруулалтыг чиглүүлнэ.

Гарааны зээлийн санхүүжилтийн хэрэгсэл нэвтрүүлснээр ЕСБХБ-ны гарааны бизнесийг дэмжих бүтээгдэхүүнийг хувь эзэмших хэлбэрээс хальж өргөжүүлсэн дэвшил хийх бөгөөд ЕСБХБ-ны бүс нутаг дахь өсөлтийн үедээ байгаа гарааны бизнесийг санхүүжүүлэх чиглэлээр зах зээл дээрээ оршиж байгаа хийдлийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах юм.

Төслийн зорилго

“Гарааны капитал хөрөнгө оруулалтын хөтөлбөр – Гарааны өрийн санхүүжилт” (VCIP-VD) арга хэмжээний зорилго нь i) технологид суурилсан, инновацийг дэмжигч бизнес аж ахуйн нэгжүүдийн өргөжин тэлэх явдлыг дэмжих, ii) өсөлтийн үедээ байгаа гарааны бизнес дэх хувь эзэмшлийн капитал санхүүжилтийн олдоц хязгаарлагдмал, гарааны өрийн санхүүжилт үндсэндээ байхгүй байгаа бүс нутгуудад гарааны өрийн зах зээл хөгжүүлэх явдал байх юм.

VCIP-VD механизм нь “Гарааны капитал хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хүрээн дэх өргөтгөсөн хүчин чармайлтын нэг нэмэлт хэрэгсэл болох бөгөөд тус Банкинд i) бүс нутгуудад мэдлэгийн эдийн засгийг хөхиүлэн дэмжих, технологийн экосистем хөгжүүлэх, инновацийг дэмжих боломж олгож, ii) VCIP хөтөлбөрөөр дамжуулан, бүс нутагт тулгарч байгаа гарааны капитал санхүүжүүлтийн хийдлийг арилгахад чухал үүрэг ногдуулан, iii) өндөр эрсдэлтэй боловч өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын боломжуудад хувь эзэмших бодлогоор хандах бололцоо олгож байна.

Шилжилтийн нөлөөлөл

Хүлээгдэж буй шилжилтийн нөлөөлөл (ETI)-ийн оноо: 80

“Гарааны капитал хөрөнгө оруулалтын хөтөлбөр – Гарааны өрийн санхүүжилт” (VCIP-VD) механизм нь өндөр инновацтай технологид суурилсан компаниудад тусалж, мөн ЕСБХБ-ны бүс нутагт бараг байхгүй байгаа гарааны өрийн санхүүжилтийн олдоц нэмэгдэх явдлыг хөхиүлэн дэмжих учир “Шилжилтийн өрсөлдөх, тэсвэрлэх чанарууд”-ад хувь нэмэр оруулах хүлээлттэй байна. VCIP-VD арга хэмжээ нь VCIP I болон VCIP II хөтөлбөрүүдийн амжилтанд дөрөөлөн хэрэгжих бөгөөд ЕСБХБ-ны “Мэдлэгийн эдийн засгийн санаачилга” бодлогын дагуу бүс нутаг дахь мэдлэгийн эдийн засгийн хөгжилд чухал дэмжлэг болох юм.

Харилцагчийн мэдээлэл

Тухай бүрт.

ЕСБХБ-ны санхүүжилтийн хураангуй

100,000,000.00 евро

Төслийн нийт өртөг

120,000,000.00 евро

Нэмэлт ашиг тус

ЕСБХБ нь бусад банкнаас болон ЕСБХБ-ны бүс нутагт зориулсан гарааны өрийн санхүүжилтийн сангуудаас олдохгүй байгаа инновацид суурилсан санхүүгийн

хэрэгсэл болох гарааны өрийн санхүүжилтийг VCIP-VD хөтөлбөрөөр дамжуулан арилжааны нөхцлөөр олгоно.

Байгаль орчин, нийгмийн шаардлагын тойм

Энэхүү (VCIP-VD) механизм Банкны “Байгаль орчин, нийгмийн бодлого” (2019)-ын дагуу ангилагдаагүй боловч түүний дэд төслүүд нь тухай бүртээ ямар нэг ангилалд орох бөгөөд тухайн төсөл болон үйлчлүүлэгч бүрийн онцлогт нийцүүлсэн Байгаль орчин, нийгмийн нарийвчилсан үнэлгээ (ESDD), Ногоон эдийн засгийн шилжилт (GET)-ийн шинжилгээнд хамрагдах болно. Тухайн дэд төслийн ангилал дээр үндэслэн, дэд төсөл тус бүр ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шалгууруудад нийцсэн бүтэцтэй байгаа эсэхийг холбогдох Байгаль орчин, нийгмийн нарийвчилсан үнэлгээгээр шалгаж тогтооно.

Техник хамтын ажиллагаа ба буцалтгүй тусламжийн санхүүжилт

Байхгүй

Компаниудын холбоо тогтоох мэдээлэл

Бакром Ибрагимов
02073386000

ТХББ-ийг хамгийн сүүлд шинэчилсэн огноо

2021 оны 2 дугаар сарын 5

Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга барилын талаарх нэмэлт мэдээллийг эндээс авна уу.

Бизнесийн боломжууд

Бизнесийн боломжууд болон худалдан авах ажиллагааны талаар харилцагч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хийх бизнесийн боломжууд (худалдан авах үйл ажиллагаатай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168
Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл ЕСБХБ-ны Худалдан авах ажиллагаа хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794
Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг ЕСБХБ-ны Лавлагааны маягт ашиглан авах боломжтой.

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

БОНБ болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн тухайд харилцагчдын дагаж мөрдөх ёстой үндэсний хууль тогтоомжийн холбогдох шаардлагуудад нийцүүлэх, мөн оролцогч талуудын санаа зовнил, гомдол, ялангуяа харилцагч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн харилцагчдадаа тухайн төслийн улмаас үүссэн эрсдэл, үр нөлөөллийн тухай зохих мэдээллийг ил болгох, эсвэл оролцогч талуудтай чухал ач холбогдолтой байдлаар зөвлөлдөх, тэднээс ирүүлсэн санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу илгээх нэмэлт шаардлага тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг арга туршлагын талаарх нэмэлт мэдээллийг БОНБ-д оруулсан болно.

Шударга ёс ба Хянан нийцүүлэлт

ЕСБХБ-ны Хянан нийцүүлэлт хариуцсан Захирлын Ажлын алба (ХНЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг арга туршлагад нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаанд шударга ёсыг хамгийн дээд түвшинд хангахад анхаардаг. Төслүүд нь Банкинд шударга ёс, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд Банк бүх

харилцагчиддаа шударга ёсны магадлах шалгалт хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны ажил гүйлгээний шударга ёсыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. ХНЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэх ба төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах шударга ёсны эрсдэлийг хянахад тус болдог.

Түүнчлэн, ХНЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга болон хууль бус үйлдлийн талаарх мэдэгдлийн мөрөөр судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд дотроос эсвэл гаднаас залилан мэхлэлт болон авилга үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй хэн ч гэсэн Хянан нийцүүлэлт хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаягаар бичгээр мэдэгдэл илгээх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлуудын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг ХНЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүхий л мэдэгдлийг шалгана. Мэдэгдлийг Банкны үйл ажиллагаанд ашиглагддаг буюу үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын үалбан ёсны хэлний алинаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь шударга үнэн байх ёстой.

Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил болгох, уг бодлого 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг заана. ЕСБХБ-ны вэб хуудаснаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдэхийн тулд Мэдээллийн хүртээмжийн бодлого хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтийг ЕСБХБ-ны Лавлагааны Маягт ашиглан илгээх боломжтой.

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв Харилцагч эсвэл Банкинд хамаатай байгаль орчны, нийгмийн буюу мэдээллийг олон нийтэд ил болгохтой холбоотой асуудлыг шийдвэрлэх оролдлого, хүчин чармайлт нь (жишээлбэл: Харилцагчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харьцах замаар) амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд өөрсдийн санал гомдлыг ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ) –аар дамжуулан шийдвэрлүүлэхийг эрмэлзэж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан гэж үзэж буй (эсвэл учруулж болзошгүй) асуудлуудыг хараат бусаар шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчны, нийгмийн болон мэдээллийг олон нийтэд ил болгохтой холбоотой асуудлыг шийдвэрлэх чиглэлд Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлцлийг дэмжих; Банк өөрийн Байгаль орчин, нийгмийн бодлого эсвэл Мэдээллийн хүртээмжийн бодлого–ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс ирээдүйд эдгээр бодлогуудад үл нийцсэн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ нэгэнт бий болсон зөрчлүүдийг арилгаж шийдвэрлэхэд оршино.

Манай нууц онлайн маягт –ыг ашиглан, цахим шуудан-гаар, шуудан эсвэл утсаар хэрхэн Өргөдөл, гомдол гаргах талаар мэдэхийг хүсвэл Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб хуудсанд хандана уу. ТХХБМ нь таны санааг зовоосон асуудлын талаар ярилцах, Өргөдөл, гомдол мэдүүлэх, түүнийг Төслийн хариуцлагын бодлого ба Удирдамж –ийн дагуу хэрхэн хянан шийдвэрлэх тухайд таны бүхий л асуултанд хариулахад бэлэн байна. Өргөдөл, гомдол гаргагчдын хувийн мэдээллийг хүсэлтийн дагуу нууцалж болно.